

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2026 МОНГОЛЫН ТҮҮХ

ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ Хувилбар: А

1. Эртний хүмүүс галыг хэзээ эзэмшсэн бэ? (1 оноо)
А. Дээд палеолит В. Доод палеолит С. Дунд палеолит
D. Мезолит E. Неолит
2. Мезолитын үед аль нь холбогдох вэ? (2 оноо)
А. Монгол нутагт нүүдлийн мал аж ахуй үүссэн
В. Модны уян харимхай чанарыг ашиглан нум сум зохион бүтээсэн
С. Хэл яриа үүсч хүмүүс мэдлэгээ хуваалцах боломж нэмэгдсэн
D. Зэсийг тугалгатай хольж хүрэл боловсруулалт эхэлсэн
E. Монгол нутагт хадны зургийн үүсэл тавигдсан
3. Буган хөшөө археологийн аль үеийн дурсгал вэ? (1 оноо)
А. Дээд палеолит В. Мезолит С. Неолит
D. Хүрэл, түрүү төмөр E. Хүннү
4. Дөрвөлжин булшийг зөв оновчтой тодорхойлно уу. (1 оноо)
А. Тэгш дөрвөлжин хэлбэртэй чулуун байгууламж бүхий оршуулгын дурсгал
В. Монгол орны төв ба баруун хэсгээр өргөн тархсан оршуулгын дурсгал
С. Чулуун зэвсгийн үеийн оршуулгын дурсгал
D. Гол төлөв хүн чулуутай хамт цогцолбор байдлаар оршдог дурсгал
E. Евразид тархсан, Монгол нутгаас 1200 гаруйг илрүүлж судалжээ
5. Монгол орны төв ба баруун хэсгээр хиргисүүр, төв ба зүүн хэсгээр дөрвөлжин булш өргөн тархсан байдаг. Үүнд зөв оновчтой дүгнэлт өгнө үү. (2 оноо)
А. Монгол нутагт эртний хүн нутаглах болсныг гэрчилдэг түүхийн дурсгалууд мөн
В. Монгол нутагт мал аж ахуй, тариалан эрхлэгчид нутаглаж байжээ
С. Монгол нутагт нүүдлийн ба суурин ард түмнүүд өрсөлдөж байжээ
D. Монгол нутагт хоёр өөр шашин бүхий овог аймгууд нутаглаж байжээ
E. Монгол нутагт угсаа-соёлын ялгаатай нүүдэлчид нутаглаж байжээ
6. НТӨ 198 онд Хань улс Хүннүг эн чацуу хүчирхэг улс болохыг хүлээн зөвшөөрч, хоёр улсын хил хаагуур тогтсон бэ? (1 оноо)
А. Торгоны зам дагуу В. Монголын их говиор
С. Хөх мөрний араар D. Урт Цагаан хэрмээр
E. Шиньжяны өмнөд биеэр
7. Хань улсын "Хүннүгийн баруун гарыг тасдах бодлого" гэж юу вэ? (2 оноо)
А. Хүннүгийн язгууртнуудыг урвуулах
В. Хүннү улсын баруун сэцэн вангийн эзэмшлийг эзлэх
С. Дорнод Туркестан, Дундад Азид Хүннүтэй өрсөлдөж, тус бүс нутгийг Хүннүгийн эрхшээлээс салгах
D. Хүннүгийн баруун талаар тойрч довтлох
E. Сяньби, Ухуань нарыг Хүннүгийн эсрэг турхирах
8. Сяньби нэгдсэн улс 235 онд задарсан. Уг оныг зуунаар илэрхийлнэ үү. (1 оноо)
А. НТӨ II зууны эхэн В. НТ III зууны I хагас
С. НТӨ III зууны II хагас D. НТӨ III зууны 30-аад он
E. НТӨ II зууны II хагас

9. Уйгурууд ямар улсыг мөхөөж төр улсаа байгуулсан бэ? (1 оноо)
А. Хүннү В. Сяньби С. Жужан
D. Түрэг E. Хятан
10. Монголын эртний нүүдэлчдийн үндсэн аж ахуй юу вэ? (1 оноо)
А. Нүүдлийн мал аж ахуй В. Газар тариалан
С. Гар урлал D. Ан гөрөө E. Төмөрлөгийн үйлдвэрлэл
11. Онон мөрний эхэнд Тэмүжинг Монгол улсын хаанд өргөмжлөхөд тэрээр хэдэн настай байсан бэ? (1 оноо)
А. 29 В. 33 С. 37 D. 65 E. 44
12. Чингис хаан "Хатгалдаанд амиа өрж урьд ам нээсний тусын тулд ургийн урагт хүртэл өнчдийн авилга аван автугай" хэмээн зарлиг буулгажээ. Уг зарлигийн утгыг зөв тайлна уу. (2 оноо)
А. Өнчин ядуусаас авилга авч болохгүй тухай
В. Дайнд үрэгдэгсдийн гэр бүлээс авилга авахгүй тухай
С. Үеийн үед авилга хээл хахуулийг жигших тухай
D. Дайнд үрэгдэгсдийн гэр бүлд халамж үзүүлэх тухай
E. Авилга авагчийг илчилсэн хүнийг шагнах тухай
13. Тархай бутархай Монгол овог аймгуудыг нэгтгэн захирсан хаан хэн бэ? (1 оноо)
А. Гүр хаан Жамуха В. Амбагай хаан С. Хотула хаан
D. Есүхэй баатар E. Чингис хаан
14. Их Монгол улсад "Их засаг" хуулийг хэн тогтоож байсан бэ? (1 оноо)
А. Чингис хаан В. Мухулай С. Боорчи
D. Наяа E. Шихихутуг
15. Улсынх нь хүн ам Мавераннахр, Могулистан хэмээн хоёр хэсэгт хуваагдаж байсан улс аль вэ? (1 оноо)
А. Ил хаант улс В. Юань улс С. Цагадайн улс
D. Их Монгол улс E. Алтан ордны улс
16. Монголын Юань улсын газар нутгийг зөв тодорхойлсон нь аль вэ? (2 оноо)
А. Монгол, Хятад, Солонгос, Япон
В. Монгол, Хятад, Солонгос, Өмнөд Азийн орнууд
С. Хятад, Иран, Ирак, Монгол
D. Хятад, Гүрж, Турк, Монгол
E. Монгол, Хятад, Иран, Ирак
17. Засагт хан, Түшээт хан, Сэцэн хан аймгуудаас бүрдэж байсан улс аль вэ? (1 оноо)
А. Цахар улс В. Халимаг улс С. Зүүнгар улс
D. Халх улс E. Хошууд улс
18. Лигдэн хааны бодлого, үйл ажиллагаанд аль нь хамаарах вэ? (1 оноо)
А. Төвөдөөс Ширваа хутагтыг залж "Улсын багш" болгов
В. Лигдэн хааны зарлигаар Хутагтай сэцэн хунтайж шашны цааз зохиов
С. Халх - Ойрадын ноёдтой хамтарч "Их цааз"-ыг тогтоов
D. Халх - Ойрадын ноёд оролцсон Засгийн газар байгуулав
E. Хөвгүүдээ харьяат нутгаа өмч болгон хувааж өгөв

19. 1640 онд Халх - Ойрадын ноёд "Их цааз" хэмээх хуулийг батлах болсон шалтгаан юу вэ?
 А. Хошууд улсын эсрэг хүчээ нэгтгэхийн тулд (2 оноо)
 В. Монголд бурхны шашны улааны урсгалыг дэлгэрүүлэх зорилгоор
 С. Өвөр Монгол Манжид эзлэгдэж харийн түрэмгийлэл ойртсон учир
 D. Монголын их хааны засаглалыг сэргээх зорилгоор
 E. Ижил мөрний зүг нүүсэн торгуудыг буцаан авчрах үүднээс
20. Зая бандида Намхайжамцын зохиосон үсэг аль вэ? (1 оноо)
 А. Соёмбо үсэг В. Тод үсэг С. Али гали үсэг
 D. Вагиндра үсэг E. Дөрвөлжин үсэг
21. Халхын шарын шашны анхны тэргүүн хэн бэ? (2 оноо)
 А. Зая бандид Лувсанпринлэй В. Нэйж тойн
 C. Зая бандид Намхайжамц D. Өндөр гэгээн Занабазар
 E. Аюуш гүүш
22. Монголд бурхны шашин дэлгэрсний эерэг нөлөө аль вэ? (2 оноо)
 А. Монголчуудыг энэрэнгүй, номхон хүлцэнгүй болгосон
 B. Алтан ургийн язгууртнууд оны цол хэрэглэх болсон
 C. Монголчуудын оюун санааны нэгдмэл байдлыг хангах болсон
 D. Хүн амын өсөлтөнд эерэгээр нөлөөлсөн
 E. Монголчуудаас авах Манжийн төрийн алба татвар буурсан
23. Зүүнгар улс Манж Чин улсад хэдэн онд эзлэгдсэн бэ? (1 оноо)
 А. 1691 он В. 1755 он С. 1731 он
 D. 1759 он E. 1771 он
24. Өвөр Монгол Манжийн эрхшээлд орсон үйл явдлыг олж тогтооно уу. (1 оноо)
 А. 1755 оны Манж Чин улсын их цэргийн довтолгооноор
 B. 1691 онд Долон нуурт болсон ноёдын чуулганаар
 C. 1648 онд Манжид Сөнидийн Тэнгис ван бууж өгснөөр
 D. 1646 онд Манжид Хорчины Ууба тайж дагаж орсноор
 E. 1636 онд Мүгдэнд болсон ноёдын чуулганаар
25. XVII-XVIII зуунд монголчууд ээлж дараалан Манжийн эрхшээлд орсон. Монголчууд Манжид эзлэгдсэнийг он цагийн дарааллыг баримталж, эхлэлээс төгсгөл рүү нь зөв эрэмбэлснийг олж тогтооно уу. (2 оноо)
 А. Өвөр Монгол, Халх Монгол, Хөх нуурын Хошууд улс, Зүүнгар улс
 B. Өвөр Монгол, Хөх нуурын Хошууд улс, Халх Монгол, Зүүнгар улс
 C. Өвөр Монгол, Зүүнгар улс, Халх Монгол, Хөх нуурын Хошууд улс
 D. Өвөр Монгол, Халх Монгол, Зүүнгар улс, Хөх нуурын Хошууд улс
 E. Өвөр Монгол, Хөх нуурын Хошууд улс, Зүүнгар улс, Халх Монгол
26. Зүүнгар улсын хаан Даваач, Хойдын ноён Амарсанаа нарын зөрчил тэмцлийн үр дагаврыг тодорхойлно уу. (2 оноо)
 А. Ойрад монголчууд Орос улсын эрхшээлд ороход нөлөөлсөн
 B. Зүүнгар улсад гурван хаан зэрэг гарч, дайтах болсон
 C. Зүүнгар улсын хүн ам Орос улсын нутагт дүрвэсэн
 D. Ойрад монголчууд Хасагийн эрхшээлд ороход хүрсэн
 E. Зүүнгар улс Манжид эзлэгдэх нэг шалтгаан болсон

27. Монгол улс Манж Чин улсын эрхшээлд ороход нөлөөлсөн гадаад шалтгаанд аль нь ХАМААРАХГҮЙ вэ? (2 оноо)
 А. Мин улсын хагалан бутаргах бодлого
 B. Орос улсын газар нутгаа тэлэх бодлого
 C. Манж улсын газар нутгаа тэлэх бодлого
 D. Төвөд улсын дарамт, сүрдүүлэг
 E. Монголын захиргаанд байсан Хасаг, Хотон нарын урвалт
28. Манжийн эрхшээлийн үеийн Монгол ноёд тайж нарын харьяат ардыг хэрхэн нэрлэдэг вэ? (1 оноо)
 А. Шавь ард В. Сум ард С. Хамжлага ард
 D. Албат ард E. Харьяат ард
29. Халх Монголд гарсан Манжийн эсрэг бослогыг хэн удирдсан бэ? (1 оноо)
 А. Бүрни В. Чингүнжав
 C. Тогтох D. Сэвдэнбалжир E. Амарсанаа
30. Монгол улс тусгаар тогтнолоо зарласан өдөр аль вэ? (1 оноо)
 А. 1911.III.18 В. 1911.XI.30 С. 1911.XII.4
 D. 1911.XII.29 E. 1911.XI.26
31. 1911 оны хувьсгалд VIII Богд Жавзандамба хутагт ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? (1 оноо)
 А. Монголын ноёд язгууртнуудын хамт тусгаар тогтнолын тэмцлийг тэргүүлэн удирдсан
 B. АНУ-тай холбоо тогтоон тусламж эрэх ажлыг зохион байгуулсан
 C. Их шавийн яамд онцгой эрх олгож хувьсгалыг удирдах газар болгосон
 D. Халх, дөрвөдийн ноёдод цалин пүнлүү олгож хувьсгалын хэрэгт татан оролцуулсан
 E. Манж сайд Сандотой хэлэлцээр хийж тусгаар тогтнолоо зөвшөөрүүлсэн
32. Улсын Дээд, Доод хурал байгуулагдсаны ач холбогдол юу вэ? (2 оноо)
 А. Монголын нийгмийн бүхий л давхаргын ашиг сонирхлыг хангах бололцоо бүрдсэн
 B. Гадаад улс орнуудаар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэхэд нөлөөлсөн
 C. Ард иргэд улс төрийн хэрэгт шууд оролцох боломжтой болсон
 D. Монгол улс парламентийн засаглалд шилжсэн
 E. Улс орны хэргийг зөвлөн хэлэлцэж шийдвэрлэхэд ардчилсан зарчмыг нэвтрүүлэх алхам болсон
33. Монгол улсыг өөртөө эзэрхэх эрхтэйгээр тогтноход нь туслах, тус улсын нутаг дэвсгэрт эдийн засгийн давуу эрх олж авахыг аль улс зорьж байсан бэ? (1 оноо)
 А. АНУ В. Япон улс С. ДИУ
 D. Хаант Орос улс E. Англи улс
34. 1913 оны "Бээжингийн тунхаг бичиг"-ийн агуулга аль вэ? (1 оноо)
 А. Гадаад Монголыг ДИУ-ын муж болохыг Орос улс зөвшөөрсөн
 B. Монголын тусгаар тогтнолыг Хятад, Орос улс зөвшөөрсөн
 C. Орос улс Монголд дахь хятадын эзэн эрхийг, Монголын автономит эрхийг ДИУ тус тус зөвшөөрсөн
 D. Гадаад Монголыг Орос улсын автономит болохыг ДИУ зөвшөөрсөн
 E. Гадаад Монголыг ДИУ, Хаант Орос улс хуваан эзлэхээр тохирсон
35. 1919 онд хятад элчин Чен И Гадаад Монголын автономийг устгах гэрээг санаачлан боловсруулжээ. Тэрхүү баримт бичиг аль вэ? (2 оноо)
 А. Бээжингийн тунхаг бичиг
 B. Гадаад Монголын хойчийг сайжруулах 64 зүйл бүхий гэрээ
 C. Хятад, Орос, Монгол гурван улсын гэрээ
 D. Найрамдлын гэрээ бичиг
 E. Тангарагийн гэрээ



36. 1923 онд боловсруулсан Эдийн засгийн үндсэн бодлого хэмээх баримт бичигт "...Олон их бага улс дотроос эзэрхэг шунахай, хурц эрдэмтэй, бүдүүлэг гэх мэт дүрс чанар адилгүй бөгөөд... шилэн сонгоход хүрэл аль ч талаар Герман, Орос, Америк гэх мэтээр дэс дараалан орно" хэмээн заажээ. Уг мэдээний агуулгыг тодорхойлно уу. (2 оноо)

- A. Герман, Орос, Америк улсыг эзэрхэг шунахай, хурц эрдэмтэй, бүдүүлэг хэмээжээ
- B. Монгол улс нийгэм, эдийн засгийн хөгжлөөрөө Герман, Орос, Америкийн дараа орно
- C. Монгол улс зөвхөн Герман, Орос, Америктай улс төр, эдийн засгийн харилцаа тогтооно
- D. Монгол улсын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход нэн тэргүүнд Герман улсыг үлгэр болгох хэмээжээ
- E. Дэлхийн улсуудыг их, бага хэмээн хувааж Герман, Орос, Америкийг жишээ болгожээ

37. Ардын эрхт хэмжээт цаазат засаг Монгол улсын хөгжлийн онцлогт тохирно хэмээн үзэж байсан улс төрийн зүтгэлтэн хэн бэ? (1 оноо)

- A. Д.Бодоо
- B. Б.Элдэв-Очир
- C. З.Шижээ
- D. Э.Ринчино
- E. Ө.Бадрах

38. БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн агуулгад аль нь хамаарах вэ? (1 оноо)

- A. Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилт дэвшүүлсэн
- B. Монгол улсад улсын, хувийн, хоршооны өмчийн хэлбэрүүдийг зөвшөөрсөн
- C. МАХН бол төр нийгмийн удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин болохыг заасан
- D. Эзэрхэг түрэмгий ба феодалыг эсэргүүцсэн хувьсгалыг туйлд хүргэхээр заасан
- E. Монгол улсын иргэд угсаа, шашин, эрэгтэй эмэгтэй ялгаваргүйгээр тэгш эрхтэйг тунхагласан

39. Улс орноо хөгжүүлэхэд "Үндэсний ардчилсан" чиг шугам баримталж байсан улс төрийн зүтгэлтнүүдийг хэрхэн нэрлэж байсан бэ? (1 оноо)

- A. Шашныхан
- B. Зүүнтэн
- C. Хөдөөнийхөн
- D. Баруунтан
- E. Большевикууд

40. Зүүнтний хамтралжуулах бодлогын үр дагавар юу вэ? (1 оноо)

- A. Нийгэмд баян хоосны ялгаа нэмэгдсэн
- B. Малын тоо толгой ихээр өссөн
- C. Малын тоо толгой ихээр хорогдсон
- D. Мал аж ахуйн салбарын хөгжил түргэссэн
- E. Хувийн өмч устаж, улс хоршооллын өмч ноёрхох болсон

41. 1930-аад онд 40 гаруй мянган монголчууд нутгаа орхин нүүжээ. Ийнхүү дүрвэх болсны шалтгаан юу вэ? (2 оноо)

- A. Баруунтны алдаатай бодлого
- B. Зүүнтний алдаатай бодлого
- C. Дундад Иргэн Улсын суртал ухуулга
- D. Олон жил үргэлжилсэн ган зуд
- E. Манж Го улсын довтолгоо

42. 1932 оны зэвсэгт бослогын түүхэн сургамж юу вэ? (2 оноо)

- A. Хууль эрх зүйн сул орчин зэвсэгт бослого гарах боломж олгодгийг сануулдаг
- B. Нийгэмд баян хоосны ялгааг гүнзгийрүүлж болохгүйг сануулдаг
- C. Чинээлэг аж ахуйтнууд зөвхөн хувийн эрх ашгаа эрхэмлэдгийг сануулдаг
- D. Төр засгийн алдаатай бодлогын улмаас зэвсэгт бослого гарч болохыг сануулдаг
- E. Шашны хэт даврагчид зэвсэгт бослого гаргадгийг сануулдаг

43. 1937-1940 онд Монголд улс төрийн хэлмэгдүүлэлт гүнзгийрч, нийтийг хамрахад гол нөлөө үзүүлсэн улс аль вэ? (1 оноо)

- A. ЗХУ
- B. ДИУ
- C. Япон улс
- D. АНУ
- E. Герман улс

44. 1930-аад онд Монголд өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршиг юу вэ? (2 оноо)

- A. Япон улс шалтаг болгон Монголын хилд халдах болсон
- B. БНМАУ, ЗХУ-ын харилцаа хөндийрсөн
- C. ЗХУ эдийн засгийн тусламж үзүүлэхээ зогсоосон
- D. Монгол улсын тусгаар тогтнолыг ДИУ хүлээн зөвшөөрөхгүй байх шалтаг болгосон
- E. Олон мянган хүн амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохирсон

45. Зүүн хойд Хятад, Өвөр Монгол, Манжуурыг эзэлж Манж Го хэмээх тоглоомын улс байгуулсан улс аль вэ? (1 оноо)

- A. Герман улс
- B. ЗХУ
- C. АНУ
- D. Япон улс
- E. Англи улс

46. 1945 оны 10-р сарын 20-нд БНМАУ-д тусгаар тогтнолын асуудлаар бүх ард түмний санал хураалт явуулсан. Уг санал хураалтыг явуулах болсны учир юу вэ? (1 оноо)

- A. АНУ-аар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэхийн тулд
- B. Үндсэн хуулийн зарим заалтыг өөрчлөх эсэхийг шийдвэрлэх
- C. ДИУ-аас тавьсан болзлыг хангаж, тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэхийн тулд
- D. ЗХУ-аар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэхийн тулд
- E. Японы эсрэг дайнд оролцох эсэх асуудлаар санал хураасан

47. 1990 онд Монголд ардчилсан хувьсгал гарах болсон дотоод шалтгаан юу вэ? (1 оноо)

- A. Нийгэм дэх хөрөнгө чинээний ялгаа их болсноос
- B. Социалист байгуулалт мухардалд орж, улс төр, нийгэм, эдийн засагт хямрал нүүрлэсэн
- C. БНМАУ-д хөрөнгөтөн орнуудын үзэл суртал нэвтэрснээс
- D. Малын тоо толгой өсөлтгүй нэгэн хэвийн байх болсон учир
- E. Нам, төрийн удирдлагаас Ж.Батмөнх тэргүүтэй хүмүүсийг буулгахын тулд

48. 1989 оны 12-р сарын 10-ны өдөр Залуучуудын соёлын ордны талбайд болсон цуглаан дээр улс төрийн ямар хүчин байгуулагдсаныг зарласан бэ? (1 оноо)

- A. Шинэ үе бүлгэм
- B. Монголын Ардчилсан Нам
- C. Монголын Ардчилсан Холбоо
- D. Шинэ Дэвшилтэт Холбоо
- E. Монголын Үндэсний Дэвшлийн Нам

49. БНМАУ-д олон намын оролцоо бүхий анхны ардчилсан сонгууль хэдэн онд болсон бэ? (2 оноо)

- A. 1992 он
- B. 1991 он
- C. 1990 он
- D. 1993 он
- E. 1994 он

50. 1990 оны ардчилсан хувьсгалын ач холбогдлыг тодорхойлно уу. (2 оноо)

- A. НҮБ-д бүрэн эрхт гишүүнээр элсэх болзлыг хангасан
- B. Социалист системийн орнуудаас холдон хөндийрсөн
- C. Англи, Франц зэрэг орнуудтай дипломат харилцаа тогтоох боломж нээгдсэн
- D. Хүний эрх, эрх чөлөөг хангах нийгэм-улс төрийн тогтолцоонд шилжсэн
- E. Социалист хөгжлийн чиг баримжааг засаж сайжруулах боломжтой болсон

51. Монгол улсад үйлдвэр, үйлчилгээний салбаруудыг ямар хэлбэрээр хувьчилсан бэ? (1 оноо)

- A. Тендер зарлаж өмчлөлийн эрхийг шилжүүлсэн
- B. Гадаадын хөрөнгө оруулагчдад хувьчлах замаар
- C. Үйлдвэр, үйлчилгээний газрын дарга нарт өмчлөх эрхийг шилжүүлэх байдлаар
- D. Дуудлага худалдаагаар хувьчилсан
- E. Иргэдэд хувьцаа эзэмшүүлэх замаар

52. 1990-ээд онд Монгол улс чөлөөт үнийн тогтолцоонд шилжих болсны гол шалтгаан юу вэ?

(1 оноо)

- A. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжихийн тулд
- B. Бараа бүтээгдэхүүний үнийг тогтвортой барьж байхын тулд
- C. Ард иргэдийн амжиргааны түвшинг дээшлүүлэхийн тулд
- D. Төрөөс бараа бүтээгдэхүүний үнийг зохицуулахын тулд
- E. Гадаад валютыг дотоод зах зээлээс шахаж гаргахын тулд

53. 1991 оноос үндэсний соёл, боловсролыг сэргээн хөгжүүлэх чиглэлд хэрэгжүүлж буй бодлого аль вэ?

(1 оноо)

- A. Төр ёсны уламжлалт хоёр ёсыг сэргээв
- B. Хүн төрөлхтний биет бус соёлын өвд монгол бичгийг бүртгүүлэв
- C. Үндэсний бичиг үсэгт суралцах ажлыг эхлүүлэв
- D. Бүх ард түмний спартакиадыг зохион байгуулах болов
- E. Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэв

54. 1990 оноос хойш Монгол улсын гадаад бодлогод гарсан гол өөрчлөлт юу вэ?

(1 оноо)

- A. Япон улстай харилцах харилцаандаа түлхүү анхаарах болсон
- B. Хятад, Оростой харилцах харилцааг хязгаарлах чиг шугам баримталсан
- C. АНУ-ын эрх ашгийг түлхүү анхаарах бодлого баримталсан
- D. Бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулах болсон
- E. Баруун Европын орнуудтай тогтоосон харилцаагаа хөгжүүлэхэд түлхүү анхаарах

55. Усны нөөцийг хамгаалах, биологийн олон янз байдлын хомсдлоос сэргийлэх нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын аль чиглэлд хамаарах вэ?

(1 оноо)

- A. Монгол улсын хүрээлэн буй орчны аюулгүй байдал
- B. Монгол улсын хүний аюулгүй байдал
- C. Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал
- D. Монгол улсын дотоод аюулгүй байдал
- E. Монгол улсын гадаад аюулгүй байдал

56. 1997 онд Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар ургийн овгийг сэргээн хэрэглүүлэх болсны зорилго юу вэ?

(2 оноо)

- A. Монгол улсад жендерийн эрх тэгш байдлыг хангах
- B. Монгол улсын дотоод аюулгүй байдлын хангах
- C. Монгол улсын иргэдийн аюулгүй байдлыг хангах
- D. Монгол улсын хүүхэд, өсвөр үеийн аюулгүй байдлыг хангах
- E. Монгол улсын удмын сангийн аюулгүй байлыг хангах

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ (ДАРААЛАЛ СЭРГЭЭХ) ДААЛГАВАР

Санамж:

- a. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.
- b. Зөв хариулт бүр нэг оноотой.

2.1. Түүхэн үйл явдлын он цагийг зөв тогтооно уу. (6 оноо)

- | | |
|--|------------|
| a. Чингис хаан Муу өндрийн байлдаанаар Хэрэйдийг мөхөөв | 1. 1162 он |
| b. Онон мөрний эхэнд Их Монгол улсыг тунхаглав | 2. 1189 он |
| c. Онон мөрний Дэлүүн болдогт Тэмүжин мэндлэв | 3. 1202 он |
| d. Хар зүрхний Хөх нуурт Тэмүжинг хаанаар өргөмжлөв | 4. 1203 он |
| e. Чингис хаан Далан нөмрөгийн байлдаанаар Татаруудыг мөхөөв | 5. 1204 он |
| f. Чингис хаан Наху гүний тулалдаанаар Найманыг мөхөөв | 6. 1206 он |

2.2. Түүхэн үйл явдлын он цагийг зөв тогтооно уу. (6 оноо)

- | | |
|---|---------------------|
| a. Анхдугаар Үндсэн хуулийг батлав | 1. 1918 он |
| b. 1921 оны хувьсгал ялав | 2. 1921.III.1-III.3 |
| c. Хамжлагын харилцааг халав | 3. 1921.VII.11 |
| d. Тангарагийн гэрээг тогтоов | 4. 1921.XI сар |
| e. Монгол Ардын Нам байгуулагдав | 5. 1922.I.25 |
| f. Хүрээний ба Консулын дэнжийн бүлгэм байгуулагдав | 6. 1924.XI.26 |

2.3. Монголын нийгэм, соёл урлагийн зүтгэлтнүүдийг хамаарах салбартай нь харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|--|----------------|
| a. БНМАУ-ын сансрын нисгэгч | 1. Д.Нацагдорж |
| b. Хөгжмийн зохиолч, төрийн дууллын аяыг зохиогч | 2. Д.Чоймбол |
| c. Мехикогийн зуны Олимпийн мөнгөн медальт | 3. Ж.Мөнхбат |
| d. БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академийн Ерөнхийлөгч | 4. Л.Мөрдорж |
| e. Д.Сүхбаатарын хөшөөг урласан уран барималч | 5. Ж.Гүррагчаа |
| f. Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч | 6. Б.Ширэндэв |

2.4. Түүхэн үйл явдлын он цагийг зөв тогтооно уу. (6 оноо)

- | | |
|---|------------|
| a. Чингис хааны мэндэлсний 840 жилийн ойг тэмдэглэв | 1. 1992 он |
| b. Монголын нууц товчооны 750 жилийн ойг тэмдэглэв | 2. 1990 он |
| c. Монгол улсын тамирчид Олимпийн наадмаас алтан медаль хүртэв | 3. 1993 он |
| d. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль батлав | 4. 1998 он |
| e. Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль батлагдав | 5. 2002 он |
| f. Албан хэргийг монгол бичгээр хөтлөх бэлтгэлийг хангах тогтоол гаргав | 6. 2008 он |

№	Зөв хариу	Оноо
1	A	1
2	B	2
3	D	1
4	A	1
5	E	2
6	D	1
7	C	2
8	B	1
9	D	1
10	A	1
11	E	1
12	D	2
13	E	1
14	A	1
15	C	1
16	B	2
17	D	1
18	A	1
19	C	2
20	B	1
21	D	2
22	C	2
23	B	1
24	E	1
25	A	2
26	E	2
27	D	2
28	C	1
29	B	1
30	D	1
31	A	1
32	E	2
33	D	1
34	C	1
35	B	2

№	Зөв хариу	Оноо
36	D	2
37	A	1
38	E	1
39	D	1
40	C	1
41	B	2
42	D	2
43	A	1
44	E	2
45	D	1
46	C	1
47	B	1
48	C	1
49	C	2
50	D	2
51	E	1
52	A	1
53	C	1
54	D	1
55	A	1
56	E	2
2.1	a4	1
	b6	1
	c1	1
	d2	1
	e3	1
	f5	1
2.2	a6	1
	b3	1
	c5	1
	d4	1
	e2	1
2.3	f1	1
	a5	1
	b4	1
	c3	1
	d6	1
	e2	1
2.4	f1	1
	a5	1
	b2	1
	c6	1
	d4	1
	e3	1